



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 83

Тавин

2023 оны 2 дугаар ээлжийн цэрэг
татлага явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны А/545 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2023 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Уранцэцэг (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Н.Цэрэнчунт (Архив, Бичиг хэргийн ажилтан)

Гишүүдэд: Ж.Батжаргал (1 дүгээр багийн Засаг дарга)

Ю.Туяамаа (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Төмөрчөдөр (3 дугаар багийн Засаг дарга)

Э.Сэржмядаг (4 дүгээр багийн Засаг дарга)

Ё.Адилбиш (5 дугаар багийн Засаг дарга)

С.Отгонбаяр (Эрүүл мэндийн төвийн даргын

үүргийг түр орлон гүйцэтгэгч)

О.Анхбаяр (Хэсгийн цагдаа)

Б.Биндэръяа (Нийгмийн даатгалын байцаагч)

О.Гантулга (Насан туршийн боловсролын арга

зүйч)

2. Цэрэг татлагын товчоогоор орох цэргийн насны иргэдэд зарлан дуудах мэдэгдлийг албан ёсоор хүргүүлэн тэдгээрийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Цэрэг татлагын үеэр суманд гарч болзошгүй гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх таслан зогсоох хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Хэсгийн цагдаа (О.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

4. 2023 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг сумандаа зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

5. Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Уранцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ